



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/347/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261628 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: Л.Мөнхцацрал
Утас: 261740 Цахим хаяг: munkhtsatsrall@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

| | |
|--|----|
| 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 4 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 4 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 5 |
| 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 7 |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан..... | 8 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 10 |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 12 |
| 3. Аудитын тайлан..... | 13 |
| 3.1 Ерөнхий зүйл..... | 13 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт | 13 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 15 |
| 3.4 Материаллаг байдал | 15 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга | 15 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв..... | 16 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг | 18 |
| 3.8 Аудитын гол асуудал..... | 18 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 18 |
| 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 19 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 20 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал..... | 20 |
| 4. Аудитын илрүүлэлт | 21 |
| 4.1 Залруулсан алдаа | 21 |
| 4.3 Албан шаардлага | 21 |
| 4.4 Зөвлөмж..... | 22 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл | 0 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|--|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АХГ | Аудитын хоёрдугаар газар |
| БНСУ | Бүгд Найрамдах Солонгос Улс |
| МЭЕГ | Мал эмнэлгийн ерөнхий газар |
| НА | Нотлох ажил |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ХХААГ | Хүнс, хөдөө аж ахуйн газар |
| ХХААХҮЯ | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.02.25 № 07/386
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

\\10.10.10.20\Bichig_Kheregl\Yawsan_Bichig\2022\0225 Auditin 2 Gazar - 40.Docx

001050442

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|--------------|---|-------------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 749,063,110.87 | 660,821,549.38 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 19,800,000.00 | 25,050,000.00 |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 19,800,000.00 | 25,050,000.00 |
| 31210 | Төгрөг | 19,800,000.00 | 25,050,000.00 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | 19,800,000.00 | 25,050,000.00 |
| 33 | АВЛАГА | 117,692,184.28 | 40,382,544.28 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 108,045,784.28 | 30,736,144.28 |
| 33500 | Бусад авлага | 9,646,400.00 | 9,646,400.00 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 9,646,400.00 | 9,646,400.00 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 10,900,000.00 | 12,000,000.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 10,900,000.00 | 12,000,000.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 600,670,926.59 | 583,389,005.10 |
| 35100 | Түүхий эд материал | 45,619,147.83 | 29,124,307.83 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 42,384,347.83 | 20,271,047.83 |
| 35130 | Эм боох материал | 3,234,800.00 | 8,853,260.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 447,250,000.00 | 447,250,000.00 |
| 35400 | Хангамжийн материал | 107,801,778.76 | 107,014,697.27 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,597,076.00 | 6,096,959.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,631,560.00 | 1,851,460.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,858,008.00 | 6,847,688.47 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 99,715,134.76 | 92,218,589.80 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 8,526,034,561.79 | 8,929,846,491.79 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 8,526,034,561.79 | 8,929,846,491.79 |
| 39200 | Биет хөрөнгө | 8,042,190,131.71 | 8,316,105,051.56 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 8,046,342,044.97 | 8,166,225,886.97 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (448,312,631.39) | (670,152,296.03) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 389,861,309.78 | 389,861,309.78 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (297,271,309.78) | (315,789,309.82) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 782,004,017.41 | 1,226,567,809.91 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (581,691,501.61) | (609,943,726.47) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 831,539,713.55 | 857,352,181.37 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (693,287,915.57) | (739,433,466.14) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 25,087,504.00 | 25,087,504.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (12,081,099.65) | (13,670,842.01) |
| 39300 | Биет бус хөрөнгө | 483,844,430.08 | 613,741,440.23 |
| 39301 | Программ хангамж | 460,171,450.00 | 651,246,450.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (308,522,749.92) | (369,700,739.77) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 332,195,730.00 | 332,195,730.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 9,275,097,672.66 | 9,590,668,041.17 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 2,220,456.00 | 0 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 2,220,456.00 | 0 |
| 41300 | Өглөг | 2,220,456.00 | 0 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 2,220,456.00 | 0 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 9,272,877,216.66 | 9,590,668,041.17 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 9,272,877,216.66 | 9,590,668,041.17 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 6,521,194,220.95 | 6,521,194,220.95 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 689,806,342.82 | 1,007,597,167.33 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,407,743,898.54 | 689,806,342.82 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (717,937,555.72) | 317,790,824.51 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,061,876,652.89 | 2,061,876,652.89 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 9,275,097,672.66 | 9,590,668,041.17 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | ҮЗҮҮЛЭЛТ | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---------------|---|--------------------------|--------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 10,039,788,559.40 | 10,172,953,510.47 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 381,657,578.00 | 884,462,678.37 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 381,657,578.00 | 884,462,678.37 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 15,738,000.00 | 26,983,542.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,938,000.00 | 6,983,542.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 9,800,000.00 | 20,000,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 323,098,702.00 | 822,280,535.90 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 42,820,876.00 | 35,198,600.47 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 9,658,130,981.40 | 9,288,490,832.10 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 5,189,863,900.00 | 5,560,729,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 5,189,863,900.00 | 5,560,729,900.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 4,468,267,081.40 | 3,727,760,932.10 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 2,993,580,000.00 | 56,900,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,474,519,857.00 | 3,650,860,932.10 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 167,224.40 | 20,000,000.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 10,084,125,593.67 | 9,853,522,595.63 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 10,084,125,593.67 | 9,853,522,595.63 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 8,663,551,166.80 | 7,837,683,382.87 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,600,807,086.47 | 2,567,813,548.32 |
| 210101 | Үндсэн цалин | 1,543,684,609.20 | 1,699,618,608.99 |
| 210102 | Нэмэгдэл | 877,407,508.14 | 680,882,487.20 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 179,714,969.13 | 187,312,452.13 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 324,212,555.25 | 337,284,951.80 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 221,867,179.65 | 236,002,691.49 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 25,063,335.12 | 25,700,266.41 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 20,991,768.90 | 20,345,173.15 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,117,533.78 | 5,021,529.15 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 51,172,737.80 | 50,215,291.60 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 228,795,800.00 | 130,689,300.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 103,897,300.00 | 56,809,100.00 |
| 210302 | Түлш, халаалт | 92,032,300.00 | 51,335,800.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 32,866,200.00 | 22,544,400.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 110,020,384.99 | 108,950,453.08 |
| 210401 | Бичиг хэрэг | 29,111,187.00 | 18,041,007.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 34,944,669.00 | 31,000,560.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 37,938,430.99 | 37,514,338.12 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,026,098.00 | 22,394,547.96 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 33,179,378.00 | 18,672,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 365,000.00 | 2,594,500.00 |
| 210602 | Тавилга | 438,000.00 | 0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 0 | 308,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 32,376,378.00 | 15,769,800.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 65,533,008.00 | 26,998,485.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 65,533,008.00 | 26,998,485.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 315,904,880.74 | 427,171,757.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 303,242,798.74 | 412,243,982.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 6,132,650.00 | 4,348,230.00 |

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 814,505.00 | 440,024.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 368,000.00 | 178,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,900,000.00 | 6,000,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 3,446,927.00 | 3,961,521.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,985,098,073.35 | 4,220,102,587.67 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,645,534,897.00 | 3,785,070,572.10 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 339,563,176.35 | 435,032,015.57 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,420,574,426.87 | 2,015,839,212.76 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 707,165,029.08 | 383,168,945.52 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 707,165,029.08 | 383,168,945.52 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 575,447,449.00 | 1,473,135,313.57 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 0 | 51,453,751.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 442,982,948.00 | 1,292,390,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 57,474,200.00 | 96,341,961.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 74,990,301.00 | 32,949,601.57 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 137,961,948.79 | 159,534,953.67 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 102,881,741.19 | 159,534,953.67 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 35,080,207.60 | 0 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | (44,337,034.27) | 319,430,914.84 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 673,600,521.45 | 1,640,090.33 |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 640,822,223.58 | 0 |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө | 12,778,297.87 | 1,640,090.33 |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал | 20,000,000.00 | 0 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | (717,937,555.72) | 317,790,824.51 |

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---------------------------------|-------------------------|-------------------------|--|
| 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 6,518,504,470.95 | 2,128,876,652.89 | 1,340,743,898.54 | 9,988,125,022.38 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 67,000,000.00 | 67,000,000.00 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 6,518,504,470.95 | 2,128,876,652.89 | 1,407,743,898.54 | 10,055,125,022.38 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 2,689,750.00 | (67,000,000.00) | 0 | (64,310,250.00) |
| Тайлант үеийн үр дүн | | | (717,937,555.72) | (717,937,555.72) |
| 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 6,521,194,220.95 | 2,061,876,652.89 | 689,806,342.82 | 9,272,877,216.66 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 6,521,194,220.95 | 2,061,876,652.89 | 689,806,342.82 | 9,272,877,216.66 |
| Тайлант үеийн үр дүн | | | 317,790,824.51 | 317,790,824.51 |
| 2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 6,521,194,220.95 | 2,061,876,652.89 | 1,007,597,167.33 | 9,590,668,041.17 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---------------|---|-------------------------|-------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 9,978,769,831.88 | 9,454,436,276.28 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 15,738,000.00 | 26,983,542.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 15,738,000.00 | 26,983,542.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 15,738,000.00 | 26,983,542.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,938,000.00 | 6,983,542.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 9,800,000.00 | 20,000,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 9,963,031,831.88 | 9,427,452,734.28 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 5,189,863,900.00 | 5,560,729,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 5,189,863,900.00 | 5,560,729,900.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 4,773,167,931.88 | 3,839,645,784.28 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 3,296,068,807.48 | 164,945,784.28 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,476,931,900.00 | 3,654,700,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 167,224.40 | 20,000,000.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | - | 27,077,050.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 9,950,385,031.88 | 9,430,982,776.28 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 9,950,385,031.88 | 9,430,982,776.28 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 8,419,352,777.73 | 7,357,330,369.24 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,599,405,422.75 | 2,568,467,610.32 |
| 210101 | Үндсэн цалин | 1,542,282,945.48 | 1,700,272,670.99 |
| 210102 | Нэмэгдэл | 877,407,508.14 | 680,882,487.20 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 179,714,969.13 | 187,312,452.13 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 322,646,161.25 | 338,851,345.80 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 220,300,785.65 | 237,569,085.49 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 25,063,335.12 | 25,700,266.41 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 20,991,768.90 | 20,345,173.15 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,117,533.78 | 5,021,529.15 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 51,172,737.80 | 50,215,291.60 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 228,795,800.00 | 130,689,300.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 103,897,300.00 | 56,809,100.00 |
| 210302 | Түлш, халаалт | 92,032,300.00 | 51,335,800.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 32,866,200.00 | 22,544,400.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 99,830,922.99 | 109,860,873.12 |
| 210401 | Бичиг хэрэг | 23,341,312.00 | 20,090,690.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 30,525,461.00 | 33,895,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 37,938,430.99 | 37,514,338.12 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,025,719.00 | 18,360,845.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 58,025,764.00 | 22,020,700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 25,211,386.00 | 5,942,900.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 438,000.00 | 308,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 32,376,378.00 | 15,769,800.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 65,533,008.00 | 26,998,485.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 65,533,008.00 | 26,998,485.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 399,580,801.74 | 371,532,415.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 386,918,719.74 | 344,604,640.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 6,132,650.00 | 4,348,230.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 814,505.00 | 440,024.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 368,000.00 | 178,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,900,000.00 | 18,000,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 3,446,927.00 | 3,961,521.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,645,534,897.00 | 3,788,909,640.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,645,534,897.00 | 3,788,909,640.00 |

| | | | |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,531,032,254.15 | 2,073,652,407.04 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 707,165,029.08 | 383,168,945.52 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 707,165,029.08 | 383,168,945.52 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 575,447,449.00 | 1,500,212,363.57 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 0 | 27,077,050.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 0 | 51,453,751.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 442,982,948.00 | 1,292,390,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 57,474,200.00 | 96,341,961.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 74,990,301.00 | 32,949,601.57 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 248,419,776.07 | 190,271,097.95 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 102,881,741.19 | 159,534,953.67 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 145,538,034.88 | 30,736,144.28 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 28,384,800.00 | 23,453,500.00 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 18,584,800.00 | 18,203,500.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 18,584,800.00 | 18,203,500.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 18,584,800.00 | 18,203,500.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 18,584,800.00 | 18,203,500.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (18,584,800.00) | (18,203,500.00) |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 9,800,000.00 | 5,250,000.00 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 10,000,000.00 | 19,800,000.00 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 19,800,000.00 | 25,050,000.00 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|--------|---|-------------------------|-------------------------|-------------------------|--------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 5,569,197,100.00 | 5,408,178,488.33 | 5,408,178,488.33 | 97.1 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 5,569,197,100.00 | 5,408,178,488.33 | 5,408,178,488.33 | 97.1 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,726,283,500.00 | 3,586,624,229.24 | 3,586,624,229.24 | 96.3 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,656,900,500.00 | 2,568,467,610.32 | 2,568,467,610.32 | 96.7 |
| 210101 | Үндсэн цалин | 1,700,272,900.00 | 1,700,272,670.99 | 1,700,272,670.99 | 100.0 |
| 210102 | Нэмэгдэл | 742,575,000.00 | 680,882,487.20 | 680,882,487.20 | 91.7 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 214,052,600.00 | 187,312,452.13 | 187,312,452.13 | 87.5 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 372,303,000.00 | 338,851,345.80 | 338,851,345.80 | 91.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 261,991,000.00 | 237,569,085.49 | 237,569,085.49 | 90.7 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 27,578,000.00 | 25,700,266.41 | 25,700,266.41 | 93.2 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 22,062,400.00 | 20,345,173.15 | 20,345,173.15 | 92.2 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,515,600.00 | 5,021,529.15 | 5,021,529.15 | 91.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 55,156,000.00 | 50,215,291.60 | 50,215,291.60 | 91.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 130,689,300.00 | 130,689,300.00 | 130,689,300.00 | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 56,809,100.00 | 56,809,100.00 | 56,809,100.00 | 100.0 |
| 210302 | Түлш, халаалт | 51,335,800.00 | 51,335,800.00 | 51,335,800.00 | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 22,544,400.00 | 22,544,400.00 | 22,544,400.00 | 100.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 111,354,700.00 | 109,860,873.12 | 109,860,873.12 | 98.7 |
| 210401 | Бичиг хэрэг | 20,158,800.00 | 20,090,690.00 | 20,090,690.00 | 99.7 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 33,943,900.00 | 33,895,000.00 | 33,895,000.00 | 99.9 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 38,885,800.00 | 37,514,338.12 | 37,514,338.12 | 96.5 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 18,366,200.00 | 18,360,845.00 | 18,360,845.00 | 100.0 |
| 2105 | Нормативт зардал | 110,400.00 | - | - | 0.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 110,400.00 | - | - | 0.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 41,450,600.00 | 40,224,200.00 | 40,224,200.00 | 97.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 24,877,100.00 | 24,146,400.00 | 24,146,400.00 | 97.1 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 374,800.00 | 308,000.00 | 308,000.00 | 82.2 |
| 210604 | Урсгал засвар | 16,198,700.00 | 15,769,800.00 | 15,769,800.00 | 97.4 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 33,430,200.00 | 26,998,485.00 | 26,998,485.00 | 80.8 |
| 210702 | Дотоод албан томилолт | 33,430,200.00 | 26,998,485.00 | 26,998,485.00 | 80.8 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 380,044,800.00 | 371,532,415.00 | 371,532,415.00 | 97.8 |

| | | | | | |
|-------------|--|-------------------------|-------------------------|-------------------------|--------------|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 350,525,900.00 | 344,604,640.00 | 344,604,640.00 | 98.3 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 4,631,600.00 | 4,348,230.00 | 4,348,230.00 | 93.9 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,944,100.00 | 440,024.00 | 440,024.00 | 22.6 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 600,000.00 | 178,000.00 | 178,000.00 | 29.7 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 18,000,000.00 | 18,000,000.00 | 18,000,000.00 | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 4,343,200.00 | 3,961,521.00 | 3,961,521.00 | 91.2 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,842,913,600.00 | 1,821,554,259.09 | 1,821,554,259.09 | 98.8 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 384,274,500.00 | 383,168,945.52 | 383,168,945.52 | 99.7 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 384,274,500.00 | 383,168,945.52 | 383,168,945.52 | 99.7 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,458,639,100.00 | 1,438,385,313.57 | 1,438,385,313.57 | 98.6 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 37,077,700.00 | 36,703,751.00 | 36,703,751.00 | 99.0 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 1,296,200,000.00 | 1,292,390,000.00 | 1,292,390,000.00 | 99.7 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 112,269,500.00 | 96,341,961.00 | 96,341,961.00 | 85.8 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 13,091,900.00 | 12,949,601.57 | 12,949,601.57 | 98.9 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 5,569,197,100.00 | 5,408,178,488.33 | 5,567,713,442.00 | 97.1 |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 5,560,729,900.00 | 5,401,194,946.33 | 5,560,729,900.00 | 97.1 |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 5,560,729,900.00 | 5,401,194,946.33 | 5,560,729,900.00 | 97.1 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 8,467,200.00 | 6,983,542.00 | 6,983,542.00 | 82.5 |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 8,467,200.00 | 6,983,542.00 | 6,983,542.00 | 82.5 |

/төгрөгөөр/

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|-------------|---|------------|-------------------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 3,839,645,784.28 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 3,839,645,784.28 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 3,788,909,640.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 3,788,909,640.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 3,788,909,640.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 50,736,144.28 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 20,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 20,000,000.00 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | | 30,736,144.28 |
| 213305 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг | | 30,736,144.28 |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | | 3,839,645,784.28 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 3,839,645,784.28 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 164,945,784.28 |
| 131103 | ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 3,654,700,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 20,000,000.00 |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад хөрөнгийн ашиглалт, бүртгэл, тайлагналыг сайжруулах, Худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 21-ний хооронд аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Л.Мөнхцацрал, аудитор Ц.Мөнхтуяа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 01/250 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Салбарын бодлогыг оновчтой тодорхойлж хэрэгжүүлэх замаар түүхий эдийн нөөцийг зохистой ашиглах, импортыг орлох, экспортын баримжаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үнэ цэнийн сүлжээг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн орлого, бүтээмжийг өсгөн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн салбарын эдийн засгийн өсөлтийг тогтвортой нэмэгдүүлэх, хүн амыг эрүүл, баталгаат, шим тэжээллэг хүнс, эрүүл ахуй, хэрэглээний шаардлага хангасан хувцас, хэрэгслээр хангах нөхцөлийг бүрдүүлэх” гэж тодорхойлсон байна.

Тус яам нь тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааны эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан стратегийн зорилтыг хэрэгжүүлнэ: Үүнд:

- төрийн захиргааны удирдлагаар хангах, бүтцийн дотоод зохицуулалт, үйлчилгээг эрхлэх, салбарын хүний нөөцийн бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх, салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх;
- мал аж ахуй, мал эмнэлэг, газар тариалан, хүнсний болон хөнгөн, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо, дотоод худалдааны салбарын хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн төсөл, урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөл боловсруулах, бодлогын үр нөлөөний үнэлгээ хийж удирдамжаар хангах, хоёр талын болон олон талт гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх, салбарын чиглэлээр төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, салбарын статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээ, мэдээллээр хангах;
- мал аж ахуйн үйлдвэрлэлийн бодлого болон малын генетик нөөцийг бүртгэх, төлөв байдлыг тодорхойлох, хадгалах, хамгаалах, тогтвортой ашиглах, судлан хөгжүүлэх, мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;
- газар тариалангийн үйлдвэрлэлийн бодлого болон хөрс, ургамал хамгаалал, үр сортын шинэчлэлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;
- хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;

- хүнс, хоол үйлдвэрлэл, дотоод худалдааны бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;
- салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах;
- төсвийн ерөнхийлөн захирагчийн эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагаа, худалдан авах ажиллагааг зохион байгуулах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомжид өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”;

Тус яамны санхүүгийн үйл ажиллагаанд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн А/385 дугаар тушаалаар баталсан салбарын төсөвт байгууллагуудад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна.

Засгийн газрын 2020 оны 50 дугаар тогтоолоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц орон тооны хязгаарыг 105 байхаар баталсан байна. Тайлант оны гүйцэтгэлээр 116 албан хаагчид ажилласан нь батлагдсан орон тооны хязгаараас 11 орон тоо хэтэрсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас төсвийн шууд захирагчийн байгууллагад явцын болон гүйцэтгэлийн дотоод хяналтыг дараах чиглэлээр хэрэгжүүлж, ажилласан байна. Үүнд:

- Яамны шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж шилэн дансны тайлангийн тоон мэдээллийг холбогдох маягтад үнэн зөв бөглөөгүй, тайлагнаж ирүүлсэн мэдээлэл нь shilendans.gov.mn сайтын мэдээллээс зөрүүтэй дутагдлууд байгааг ажил хариуцсан мэргэжилтэнтэй тухай бүр холбогдож, мэдээллийг залруулж, үнэн зөв тайлагнах талаар мэргэжил арга зүйгээр хангасан;
- Санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 5 зөвлөмж, 2 албан шаардлагын биелэлтийг хангуулах чиглэлээр хяналт, тавьж биелэлтийг нэгтгэн Үндэсний аудитад хүргүүлсэн;
- Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилтэд улирал бүр хяналт тавьж ажилласан бөгөөд 2021 оны 3 дугаар улирлын байдлаар давхардсан тоогоор Сайдын 214 тушаалын 236 заалтыг хяналтад авч, хэрэгжилтийг 86.4 хувиар, Төрийн нарийн бичгийн 237 тушаалын 246 заалтыг хяналтад авч, хэрэгжилтийг 88.0 хувиар үнэлж, биелэлтийн хангуулах чиглэлээр тухай бүрх зөвлөмж өгч ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл болон мөнгөн /Мөнгөн гүйлгээний тайлан/ сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг төсвийн тухай хуулийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн дагуу иж бүрэн бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсөвт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 5,569,197.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 83,538.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 315,570.4 мянган төгрөгөөр буюу 3.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, үндсэн хөрөнгийн дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|--------------------|--------------------|------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 19,800.0 | 25,050.0 | 5,250.0 |
| Авлага | 117,692.2 | 40,382.5 | (77,309.6) |
| Урьдчилгаа | 10,900.0 | 12,000.0 | 1,100.0 |
| Бараа материал | 600,670.9 | 583,389.0 | (17,281.9) |
| Үндсэн хөрөнгө | 8,526,034.6 | 8,929,846.5 | 403,811.9 |
| Нийт хөрөнгө | 9,275,097.7 | 9,590,668.0 | 315,570.4 |
| Өр төлбөр | 2,220.5 | 0.0 | (2,220.5) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 9,272,877.2 | 9,590,668.0 | 317,790.8 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 9,275,097.7 | 9,590,668.0 | 315,570.4 |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 25,050.0 мянган төгрөг болж 5,250.0 мянган төгрөгөөр өссөн нь арилжааны банкин дахь Ахмадын сангийн данснаас нэг удаагийн тэтгэмжийн зардалд 14,750.0 мянган төгрөг зарцуулж, тайлант оны эцэст 20,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлснээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 40,382.5 мянган төгрөг болж, 77,309.6 мянган төгрөгөөр буурсан нь татаас санхүүжилтийн авлагын өмнөх оны үлдэгдэл бууралттай холбоотой бөгөөд

нэмэлт санхүүжилтийн данснаас төсөвт төвлөрүүлсэн 30,736.1 мянга, он дамжиж бүртгэгдсэн хувь хүмүүсээс авах 9,646.4 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 12,000.0 мянган төгрөг болж, 1,100.0 мянган төгрөгөөр буурсан нь оны эхний үлдэгдэл 10,900.0 мянган төгрөгийн үлдэгдлийг тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрч, оны эцэст “Open gov” мэдээлэл технологийн үйлчилгээний төлбөр 12,000.0 мянган төгрөгийг урьдчилж төлсөнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 583,389.0 мянган төгрөг болж 17,281.9 мянган төгрөгөөр буурсан нь эм боох материалын үлдэгдэл 5,618.5 мянган төгрөг, түлш шатах тослох материалын үлдэгдэл 3,989.7 мянган төгрөг, бичиг хэрэг болон аж ахуйн материалын үлдэгдэл 2,719.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, тусгай зориулалтын материалын үлдэгдэл 22,113.3 мянган төгрөг, бусад хангамжийн материалын үлдэгдэл 7,496.5 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ. Тайлант онд Улсын аварга малчин өрх, аварга тариаланч хамт олон, аварга саальчин зэрэг шагнал урамшуулалд олгох 921,800.0 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансаар дамжуулан олгосон байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,929,846.5 мянган төгрөг болж 403,811.9 мянган төгрөгөөр өссөн нь урсгал зардлаас 18,203.5 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны зөвшөөрөл олгох тухай А-1/1697, А-1/1356, А-1/1579, А-1/958, А-1/1158 албан бичиг, 2021 оны 203 дугаар тогтоолоор нийт 708,177.1 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, 119,883.8 мянган төгрөгөөр конторын барилгыг капиталжуулан, 64,929.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, тайлант онд 377,523.2 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулсан зэрэгтэй холбоотой байна.

Өр төлбөрийн дансны тайлант оны эхний үлдэгдэл 2,220.5 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын татварын өглөгийг бүрэн барагдуулж, оны эцэст үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант оны үр дүн 317,790.8 мянган төгрөгөөр өсөж 9,590,668.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 133,164.9 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар өссөн нь тайлант оны үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өссөн, нийт зардал өмнөх оноос 230,603.0 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар буурсан нь Засгийн газраас гэрэл цахилгааны үнийн хөнгөлөлт үзүүлсэнтэй холбоотойгоор байр ашиглалттай холбоотой тогтмол зардал хэмнэгдсэнээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2021 оны урсгал үйл ажиллагааны орлого, зарлагын төсвийн төлөвлөгөөг 5,613,067.4 мянган төгрөгөөр боловсруулж, Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлснийг өмнөх оны батлагдсан төсвийг суурь болгон хянаж, 5,693,547.0 мянган төгрөг буюу 80,479.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Энэ нь Алдар цолтон, ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуульд заасан Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтон, төрийн шагналт, төрийн соёрхолт, ахмад дайчин, улсын ударник, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн нарт сар бүр олгох тэтгэмж, урамшууллын зардал 949,650.0 мянган төгрөгийг

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төсвийн багцаас ХХААХҮЯ-ны төсөвт шилжүүлэн төлөвлөсөнтэй холбоотой байна.

“Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулиар 2021 оны 7 дугаар сарын 07-ны өдөр төсөвт тодотгол хийн, урсгал зардлыг 3.5 хувиар бууруулж 5,493,616.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс Төсвийн тухай хуулийн 42 дүгээр зүйл, Сангийн сайдын 2018 оны 134 тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсвийн зохицуулалт хийх журам”-ын дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн Хөтөлбөр арга, хэмжээний зардлын төсвөөс 75,580.8 мянган төгрөгийг Төсвийн шууд захирагчийн төсөв хүрэлцэхгүй хөтөлбөр, арга хэмжээнд дараах зохицуулалт хийсэн байна. Тухайлбал:

- Тэтгэвэрт гарахаар төлөвлөсөн албан хаагчдын тоо 2 дахин нэмэгдсэн 23,792.4 мянган төгрөгийг тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлын төсөвт;
- Салбарын алдар цолтны төрөөс олгох тэтгэмж урамшууллын хүрэлцээгүй зардлыг санхүүжүүлэхэд 29,000.0 мянган төгрөгийг төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардлын төсөвт;
- Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын зардлын төсвийг 21,077.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тус тус зохицуулалт хийсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,560,729.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 6,983.5 мянган төгрөг төвлөрч, нийт 5,567,713.4 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 5,408,178.5 мянган төгрөгийг зарцуулж, 159,534.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны буюу цайны газрын түрээсийн орлого 1,483.7 мянган төгрөгөөр тасарсан нь Коронавируст цар тахлын улмаас түрээслэгч компанийн үйл ажиллагаа зогссоноос шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,408,178.5 мянган төгрөг буюу 97.1 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 121,884.5 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийг 21,359.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийг 8,512.4 мянган төгрөгөөр, дотоод албан томилолтын зардлыг 6,431.7 мянган төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардлыг 1,226.4 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 1,604.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

| Д/Д | Хөтөлбөр, арга хэмжээний | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|-----|--------------------------|--|--------------------|--------------------|------------------|-------------|
| | Код | Нэр | | | | |
| 1 | 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 3,317,327.7 | 3,180,512.4 | 136,815.3 | 95.9 |
| 2 | 80102 | Туслах үйл ажиллагааны зардал | 109,598.4 | 109,598.2 | 0.012 | 100.0 |
| 3 | 80103 | Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ | 299,357.4 | 296,513.6 | 2,843.8 | 99.1 |
| 4 | 80509 | Гадаадын болон олон улсын гишүүнчлэлийн хураамжийн зардал | 384,274.5 | 383,168.9 | 1,105.5 | 99.7 |
| 5 | 80704 | Ахмад дайчин алдар цолтой ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламж | 852,200.0 | 849,400.0 | 2,800.0 | 99.7 |
| 6 | 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал дэмжлэг зардал алын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх | 162,439.1 | 145,995.3 | 16,443.8 | 89.9 |
| 7 | 82533 | Сайн малчны шагнал | 440,000.0 | 442,990.0 | 1,010.0 | 99.8 |
| | | Дүн | 5,560,729.9 | 5,401,194.9 | 159,534.9 | 85.5 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засгийн газрын нөөц сангаас 3,654,700.0 мянган төгрөг, өмнөх оноос дамжин хэрэгжиж байгаа гадаадын төсөл хөтөлбөрөөс 164,945.8 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 20,000.0 мянган төгрөг, нийт 3,839,645.8 мянган төгрөгийн нэмэлт орлого бүрдүүлжээ.

Үүнээс Засгийн газрын нөөц сангаас 2021 оны “Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 303 дугаар тогтоолоор малын гоц халдварт шүлхий өвчний 6 аймагт гарсан тархалтыг зогсоох вакцины үнэд шаардлагатай 2,900,000.0 мянган төгрөг хуваарилсныг МЭЕГ-ын төсөвт, 2021 оны “Хөрөнгө гаргах тухай” 344 дүгээр тогтоолоор Монгол Улсад хоршооллын салбар үүсэж, хөгжсөний 100 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулахад 317,700.0 мянган төгрөг хуваарилсныг ЖДҮДГ-ын төсөвт тус тус шилжүүлсэн байна.

Засгийн газрын 2021 оны “Журамд өөрчлөлт оруулах тухай” 31 дүгээр тогтоолоор Улсын аварга малчин өрх, хошой аварга малчин өрхийг тоог 163 болгон нэмэгдүүлж, шагналд шаардагдах нэмэлт төсөвт 437,000.0 мянган төгрөг хуваарилсныг хүлээн авч, зориулалтын дагуу зарцуулсан байна.

БНСУ-ын санхүүжилтээр Азийн бүс нутагт хүнсний ногооны сортуудыг хөгжүүлэх төсөлд 96,432.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг бүрэн зарцуулж, чацаргана жимс боловсруулах технологийг сайжруулах төсөлд 68,513.8 мянган төгрөг олгосноос 37,777.6 мянган төгрөгийг зарцуулж, 30,736.1 мянган төгрөгийн санхүүжилтийн үлдэгдлийг төсөвт төвлөрүүлэн, авлагаар бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Засгийн газрын 2020 оны “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” 50 дугаар тогтоолоор тус яамны орон тоог 105 байхаар баталж, гүйцэтгэлээр 116 албан хаагч ажилласан бөгөөд энэ талаар аудитын үр дүнд тусгасан.

Тайлант онд 7 хөтөлбөр, 38 зорилт, 124 арга хэмжээний хүрээнд 5,560,729.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэл 97.1 хувьтай, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр 68 арга хэмжээг 100 хувь, 26 арга хэмжээг 90 хувь, 13 арга хэмжээг 70 хувь, 10 арга хэмжээг 50 хувь, 6 арга хэмжээг 30 хувийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Аудитаар илэрсэн материаллаг бус алдаа, зөрчилд үндсэн хөрөнгийн үнэлгээ ба бүртгэл, ашиглалт, хамгаалалттай холбоотой эрх, үүргийн нийцэлтэй холбоотой асуудал зонхилж байгаад анхаарч, хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 20 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд Шилэн дансны нэгдсэн цахим системд 20 төрлийн 149 мэдээлэл байршуулахаас 143 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг дутуу, 2 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*”, 6 дугаар зүйлийн 6.1-т “*Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ*” гэж заасантай тус тус нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дараах мэдээллийг холбогдох хууль, журмын дагуу мэдээлээгүй байна. Үүнд:

- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон тайланг төсвийн шууд захирагчийн түвшинд тайлагнаж мэдээлээгүй;
- Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн талаарх 11 төрлийн 432,619.1 мянган төгрөгийн тушаал, шийдвэрийг байршуулаагүй;
- Батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг мэдээлээгүй;
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийг хугацаа хоцроож байршуулсан;
- Төсвийн шууд захирагчийн төсөвт болон нэмэлт санхүүжилтээр хэрэгжүүлсэн 13 удаагийн 365,799.5 мянган төгрөгийн худалдан авалтын тендерийн ерөнхий мэдээллийг байршуулаагүй;
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг буруу мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилын хүрээнд дараах асуудлууд байна. Үүнд:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хянахад Улсын аварга малчинд олгох 372,741.0 мянган төгрөгийн гэр, 39,811.2 мянган төгрөгийн тэмдэг, 98,870.0 мянган төгрөгийн цом, нийт 511,422.2 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авахдаа төсөвт өртгийг хэсэгчлэн төлөвлөж, харьцуулалт болон хязгаарлагдмал тендерийн аргаар зохион байгуулсан байна. Мөн худалдан авах ажиллагааг цахим системээр зохион байгуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх

тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 8 дугаар зүйлийн 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", 21 дүгээр зүйлийн 21.4-т "Захиалагч урилгыг энэ хуулийн 52.1-т заасан цахим хуудсан байрлуулж, тендер шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээлнэ", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр 117,645.0 мянган төгрөгийн Тоёота Ланд круйзер маркын автомашиныг ХХААХҮЯ-наас Сэлэнгэ аймгийн ХХААГ-т, Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслөөс 209,750.0 мянган төгрөгийн Ланд-200 маркын автомашиныг ХХААХҮЯ-д тус тус шилжүүлж ашиглуулсан, орон нутгийн салбар байгууллагад 447,470.0 мянган төгрөгийн үнэ бүхий худгийн өрмийн машин, хийн компрессорыг шилжүүлсэн боловч хүлээлцсэн акт үйлдээгүй, бараа материалын дансанд үлдэгдлээр тайлагнасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 4-т "төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль дэргэдээ бие даасан гарааны компани байгуулахаас бусад тохиолдолд үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 1.2-т "Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, акталж данснаас хасах, шилжүүлэх саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ, 3.5-д "...суудлын автомашин нэмж авах, цөөрүүлэх зайлшгүй шаардлага гарвал автомашины тоо, төрөл, тогтоосон шийдвэрт өөрчлөлт оруулах тухай саналаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ" 5.1-д "Эрх бүхий байгууллагын шийдвэрээр болон бусад шаардлагаар төрийн өмчит хуулийн этгээд илүүдэлтэй буюу ашигладаггүй эд хөрөнгийг шилжүүлэх, бусад байгууллагын өмчлөлд байгаа эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авахдаа өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрлийг авч, холбогдох баримт материалыг энэхүү журамд заасны дагуу бүрдүүлэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 124,282.6 мянган төгрөгийн 8 зөвлөмжийн хэрэгжилтийг хянахад 81,743.7 мянган төгрөгийн 5 зөвлөмжийг хэрэгжүүлж, 42,52.9 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бараа материалын дансны тусгай зөвшөөрлийн зарлагын гүйлгээ, тусгай зөвшөөрлийн бүртгэлийн программ дахь тусгай зөвшөөрөл олгосон аж ахуйн нэгжийн тооноос зөрүүтэй тул Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитын цаглабарт хугацаанд татварын дансанд төвлөрүүлсэн тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийн орлогыг дараагийн аудитаар тулган шалгахар төлөвлөв.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийн хүрээнд нийт 529,930.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 465,951.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 16,700.0 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 47,278.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 63,978.7 мянган төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 83,538.0 мянган төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Бараа материалын дансанд 465,951.3 мянган төгрөгийн 13 нэр төрлийн үндсэн хөрөнгө бүртгэж, хөрөнгийг ангилал буруу бүртгэснийг залруулсан.

4.3 Албан шаардлага

1. Батлагдсан орон тооноос илүү төрийн үйлчилгээний 11 ажилтан ажиллуулж 117,295.0 мянган төгрөгийн цалингийн зардал зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Засгийн газрын 2016 оны 3 дугаар тогтоолын хавсралтын 11-д "орон тооны хязгаар 113", 2020 оны 50 дугаар тогтоолын 3 дугаар зүйлд "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны орон тооны хязгаарыг 105 байхаар тогтоосугай" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

2. Спортын тэмцээн уралдаан зохион байгуулахад 9,500.0 мянган төгрөгийн үргүй зардал гаргасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2-т "төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-д үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах; 1.6-д Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

3. БНСУ-ын санхүүжилтээр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн гүйцэтгэгчид олгосон санхүүжилтийн хэрэгжилт, бүртгэлд тавигдах хяналт сул байгаагаас төслийн хөрөнгөөс бэлтгэсэн 7,200.0 мянган төгрөгийн зөөврийн компьютерыг зориулалт бусаар ашигласан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйл "Төрийн байгууллага, албан газрын эд хөрөнгийн эрх"ийн 4-т "төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль дэргэдээ бие даасан гарааны компани байгуулахаас бусад тохиолдолд үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах", Төсвийн тухай хуулийн 10.1.11-т "төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж,

улсын төсвийн байгууллагаас нийлүүлэх арга хэмжээний чанарын шаардлагыг хангуулах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Анхны өртгөө нөхсөн 297,271.3 мянган төгрөгийн автомашины ашиглах жил, үнийг дахин тооцож, данс бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.2-д “...ашиглалтын шаардлага хангаж байгаа, дахин ашиглах боломжтой хөрөнгийн үнийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай зөвшилцөн тогтоож, дахин данс бүртгэлд тусгана” гэж заасантай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн үнийг ТӨБЗГ-тай зөвшилцөн тогтоож, данс бүртгэлд тусгах, ашиглалтыг хугацааг уртасгаж, төсвийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх

2. Бараа, материалын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний зарцуулалт, олголтын тоо зөрүүтэй, тусгай зөвшөөрлийн бодит үлдэгдлийг жилийн эцэст тоолж баталгаажуулаагүй, тэмдэгтийн хураамжийн орлогын бүрдүүлэлтэд тавих дотоод хяналт сул байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 12 дугаар зүйлийн 12.2-т Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” гэж заасанд нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Үнэт цаас олгох, хяналт тавих журам боловсруулж, мөрдөх, тэмдэгтийн хураамжийн орлого бүрдэлтэд тавих дотоод хяналтыг сайжруулах.

3. Авлагын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Өмнөх оноос шилжиж ирсэн 9,646.4 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, тайлант оны төсвөөс дараа оны мэдээлэл технологийн үйлчилгээний төлбөрт 12,000.0 мянган төгрөгийг урьдчилж шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлээс дараа жилийн төсөвт хамаарах ажил, үйлчилгээний төлбөрт урьдчилан шилжүүлэхгүй байх, он дамжсан авлагыг барагдуулах арга хэмжээ авах, төсвийг зохистой удирдах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

203 мквт газрын гэрчилгээтэй, 44,656.6 мянган төгрөгийн анхны өртөгтэй, МХЕГ-ын ашиглалтын шаардлага хангахгүй тухай 2019 оны 02 дугаар сарын 7-ны өдрийн 091/1491 дугаар дүгнэлт бүхий, ашиглах хугацаа нь дууссан, ажилчдын орон сууцыг 25,532.3 мянган төгрөгийн үлдэх өртөгтэйгөөр тайлагнасан байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь хагас бүтэн жилийн эд хөрөнгийн тооллогын дүн, өмч хамгаалах Байнгын зөвлөлтийн дүгнэлтээр цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон нь тогтоогдсон үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах саналаа энэ журамд заасан баримт, материалын хамт хагас жилд 1 удаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, оршин байх, тасалбар болголт, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Ашиглалтын шаардлага хангахгүй, элэгдлээ бүрэн нөхсөн дээрх орон сууцыг акталж, данснаас хасах талаарх саналаа ТӨБЗГ-т хүргүүлж, хөрөнгийн талаар хууль эрх зүйн хүрээнд шийдвэрлэх арга хэмжээ авах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

| № | Байгууллагын нэр | Аудитын код | Алдаа, зөрчлийн товч утга | Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулгын товч утга | Нийт алдаа зөрчил | | Залруулга | | Албан шаардлага | | Үүнээс: Хариуцлага тооцох албан шаардлага | | Зөвлөмж | |
|---------------------------------|--|-------------------------|---|--|-------------------|-----------|-----------|-----------|-----------------|---------|---|-----|---------|----------|
| | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| /мянган төгрөгөөр/ | | | | | | | | | | | | | | |
| Санхүүгийн тайлангийн асуудлаар | | | | | | | | | | | | | | |
| 1 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам-ТШЗ | АХГ-2022/347/НА-СТА-ТШЗ | Төслийн хөрөнгөөр бэлтгэсэн 7,200.0 мянган төгрөгийн зөөврийн компьютерыг зориулалт бусаар ашигласан байна. | Дотоод хяналтыг сайжруулах зөвлөмж | 1 | 7,200.0 | | | 1 | 7,200.0 | | | | |
| 2 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам-ТШЗ | АХГ-2022/347/НА-СТА-ТШЗ | Батлагдсан орон тооноос илүү төрийн үйлчилгээний 11 ажилтан ажиллуулж 117,295.0 мянган төгрөгийг цалингийн зардалд зарцуулсан. | Батлагдсан орон тоог мөрдөж ажиллах албан шаардлага | 1 | - | | | 1 | | | | | |
| 3 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам-ТШЗ | АХГ-2022/347/НА-СТА-ТШЗ | Спортын тэмцээн уралдаан зохион байгуулахад 9,500.0 мянган төгрөгийн үргүй зардал гаргасан. | Төсвийн хэмнэлтэд шилжүүлэх албан шаардлага | 1 | 9,500.0 | | | 1 | 9,500.0 | | | | |
| 4 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам-ТШЗ | АХГ-2022/347/НА-СТА-ТШЗ | Өмнөх оноос шилжиж ирсэн 9,646.4 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, 12,000.0 мянган төгрөгийг урьдчилж шилжүүлсэн. | Авлагыг бууруулах зөвлөмж | 1 | 21,646.4 | | | | | | | 1 | 21,646.4 |
| 5 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам-ТШЗ | АХГ-2022/347/НА-СТА-ТШЗ | Анхны өртгөө нөхсөн 297,271.3 мянган төгрөгийн автомашины ашиглах жил, үнийг дахин тооцож, данс бүртгэлд тусгаагүй байна. | Хөрөнгийг үнэлж ашиглах зөвлөмж | 1 | - | | | | | | | 1 | - |
| 6 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам-ТШЗ | АХГ-2022/347/НА-СТА-ТШЗ | 203 мквт газрын гэрчилгээтэй, 44,656.6 мянган төгрөгийн анхны өртөгтэй, ашиглах хугацаа нь дууссан ажилчдын орон сууцыг 25,532.3 мянган төгрөгийн үлдэх өртөгтэйгээр тайлагнасан байна. | Хөрөнгийг актлак зөвлөмж | 1 | 25,532.3 | | | | | | | 1 | 25,532.3 |
| 7 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн | АХГ-2022/347/НА-СТА-ТШЗ | Бараа материалын дансанд 465,951.3 мянган төгрөгийн 13 | Үндсэн хөрөнгийн дансанд | 2 | 465,951.3 | 2.0 | 465,951.3 | | | | | | |

**Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

| | | | | | | | | | | | | | |
|---|--|-------------------------|--|--|-----------|--------------------|----------|------------------|----------|------------------|--|----------|-----------------|
| | Үйлдвэрийн яам-ТШЗ | | нэр төрлийн үндсэн хөрөнгө бүртгэсэн | залруулга хийлгэв | | | | | | | | | |
| 8 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам-ТШЗ | АХГ-2022/347/НА-СТА-ТШЗ | Тусгай зөвшөөрлийн олголт, бүртгэлийн тоо зөрүүтэй, тэмдэгийн хураамжийн орлогын бүрдүүлэлтэд тавих дотоод хяналт сул байна. | Дотоод хяналтыг сайжруулах зөвлөмж | 1 | 100.0 | | | | | | 1 | 100.0 |
| ДҮН | | | | 529,930.0 | 9 | 529,930.0 | 2 | 465,951.3 | 3 | 16,700.0 | | 4 | 47,278.7 |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал | | | | | | | | | | | | | |
| 1 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам-ТШЗ | АХГ-2022/347/НА-СТА-ТШЗ | Эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр 117,645.0 мянган төгрөгийн автомашиныг ХХААХҮЯ-наас Сэлэнгэ аймгийн ХХААГ-т шилжүүлсэн | Хөрөнгийг шилжүүлэх зөвшөөрөл авч, хөдөлгөөнийг данс бүртгэлд тусгах | 1 | 117,645.0 | | | | | | 1 | 117,645.0 |
| 2 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам-ТШЗ | АХГ-2022/347/НА-СТА-ТШЗ | Бараа материалын дансанд эргэлт удааширсан, ашиглалтгүй 9,800.0 мянган төгрөгийн бараа материал бүртгэлтэй, эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр орон нутгийн салбар байгууллагад 447,470.0 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлсэн | Алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага | 1 | 457,270.0 | | | | | | 1 | 457,270.0 |
| 3 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам-ТШЗ | АХГ-2022/347/НА-СТА-ТШЗ | Улсын аварга малчинд олгох 372,741.0 мянган төгрөгийн гэр, 39,811.2 мянган төгрөгийн тэмдэг, 98,870.0 мянган төгрөгийн цом, нийт 511,422.2 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авахдаа нээлттэй тендер зарлаагүй | ХАА-ны хуулийн хэрэгжилтийг хангаж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага | 1 | | | | | | | 1 | |
| 4 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам-ТШЗ | АХГ-2022/347/НА-СТА-ТШЗ | Шилэн дансны нэгдсэн цахим системд 2 мэдээллийг дутуу, 2 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг байршуулаагүй | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангах | 1 | | | | | | | 1 | |
| ДҮН | | | | 574,915.0 | 4 | 574,915.0 | - | - | 4 | 574,915.0 | | - | - |
| НИЙТ ДҮН | | | | 1,104,845.0 | 13 | 1,104,845.0 | 2 | 465,951.3 | 7 | 591,615.0 | | 4 | 47,278.7 |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25. № 83/АД160043.

Улаанбаатар хот

АД-2022/347/НА-СТА-ТУС.

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны урсгал зардлаас спортын тэмцээн уралдаан зохион байгуулахад зориулан 9,500,000.00 төгрөгийг зориулалт бусаар зарцуулж, үргүй зардал гаргасан байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах", 1.6 "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулах, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, үргүй зардал гаргахгүй байхад анхаарч, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Ахлах нягтлан бодогч Ө.Мандухай нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.МӨНХЦАЦРАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban-Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-47.Docx

001080136



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 84/АД160093

Улаанбаатар хот

АХГ-2022/347/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын аварга малчинд олгох 372,741,000.00 төгрөгийн гэр, 39,811,200.00 төгрөгийн тэмдэг, 98,870,000.00 төгрөгийн цом, нийт 511,422,200.00 төгрөгийн хөрөнгийг худалдан авахдаа төсөвт өртгийг хэсэгчлэн төлөвлөж, харьцуулалтын аргаар зохион байгуулсан бөгөөд худалдан авах ажиллагааг цахим системээр зохион байгуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 8 дугаар зүйлийн 8.5 "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", 21 дүгээр зүйлийн 21.4 "Захиалагч урилгыг энэ хуулийн 52.1, 12-т заасан цахим хуудсанд байрлуулж, тендер шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээлнэ", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж байх, дээрх зөрчлийг арилгаж албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Ахлах нягтлан бодогч Ө.Мандухай нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.МӨНХЦАЦРАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг-1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-48.Docx

001080139



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 85/АД160093.

Улаанбаатар хот

АХГ-2022/347/НА-СТА-ТШЗ
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр 117,645,000.00 төгрөгийн Тоёота Ланд круйзер маркын автомашиныг ХХААХҮЯ-аас Сэлэнгэ аймгийн ХХААГ-т, Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслөөс Ланд-200 маркын автомашиныг ХХААХҮЯ-д шилжүүлэн ашиглаж байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 1.2 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, акталж данснаас хасах, шилжүүлэх саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ", 3.5 "...суудлын автомашин нэмж авах, цөөрүүлэх зайлшгүй шаардлага гарвал автомашины тоо, төрөл, тогтоосон шийдвэрт өөрчлөлт оруулах тухай саналаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ", 5.1 "Эрх бүхий байгууллагын шийдвэрээр болон бусад шаардлагаар төрийн өмчит хуулийн этгээд илүүдэлтэй буюу ашигладаггүй эд хөрөнгийг шилжүүлэх, бусад байгууллагын өмчлөлд байгаа эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авахдаа өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрлийг авч, холбогдох баримт материалыг энэхүү журамд заасны дагуу бүрдүүлэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж, үндсэн хөрөнгийг шилжүүлэх саналаа Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлэх;
2. Хөрөнгийн бүртгэл, тайлагналыг холбогдох стандарт, хууль журамд нийцүүлж үнэн зөв толилуулах, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
3. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Ахлах нягтлан бодогч Ө.Мандухай нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

C. Bay

B. My

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.МӨНХЦАЦРАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264290

1006189
10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0225_Auditin_2_Gazar-49.Docx
9019120396

001080142



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 86/АД/60093

Улаанбаатар хот

АХГ-2022/347/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус яам нь орон тооны хязгаарыг хэтрүүлэн төрийн үйлчилгээний 11 ажилтан авч ажиллуулсан 117,295,000.00 төгрөгийн цалингийн зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.3 "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2020 оны "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" 50 дугаар тогтоолын 3 дугаар зүйлд "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны орон тооны хязгаарыг 105 байхаар тогтоосугай" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бүтэц, орон тооны хязгаараас хэтрүүлэн төрийн үйлчилгээний ажилтан томилон ажиллуулсан дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Ахлах нягтлан бодогч Ө.Мандухай нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЕРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.МӨНХЦАЦРАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherem\Alban_Shaardlaga\2022\0225 Auditin 2 Газар-46.Docx

001080133



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 87/АД/60043

Улаанбаатар хот

АХГ-2022/347/НА-СТА-ТШЗ
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр орон нутгийн салбар байгууллагад 447,470,000.00 төгрөгийн үнэ бүхий худгийн өрмийн машин, хийн компрессорыг шилжүүлэхдээ хөрөнгө хүлээлцсэн акт үйлдээгүй, жилийн эцэст бараа материалын дансанд үлдэгдлээр тайлагнасан байна. Мөн бараа материалын дансанд эргэлт удааширсан, ашиглалт багатай 9,800,000.00 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 12 дугаар зүйлийн 12.2 "Хөрөнгө төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1 "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагын шийдвэрээр хөрөнгийг шилжүүлж, ажил хүлээлцсэн акт үйлдэх;
2. Бараа материалын бүртгэл, тайлагнал, ашиглалт, эргэцэд хяналт тавьж, үр дүнтэй удирдах, дээрх зөрчлийг арилган албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
3. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Ахлах нягтлан бодогч Ө.Мандухай нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.МӨНХЦАЦРАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засагийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9010.10.10.20/Bichig_Khereg/Alban_Shaardlaga/2022/0225_Auditin_2_Gazar-50.Docx
9019120396

001080145



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 88/АД160093.

Улаанбаатар хот

АХГ-2022/347/НА-СТА-ТШЗ
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд Шилэн дансны нэгдсэн цахим системд 20 төрлийн 149 мэдээлэл байршуулахаас 2 мэдээллийг дутуу, 2 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Мөн Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон тайланг төсвийн шууд захирагчийн түвшинд тайлагнаж мэдээлээгүй, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн талаарх 11 төрлийн 432,619,054.00 төгрөгийн тушаал, шийдвэрийг байршуулаагүй, батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг тэмдэглээгүй, төсвийн шууд захирагчийн төсөвт болон нэмэлт санхүүжилтээр хэрэгжүүлсэн 13 удаагийн 365,799,500.00 төгрөгийн худалдан авалтын тендерийн ерөнхий мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь, үнэн зөв, ил тод байршуулж, зөрчлийг арилган албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Ахлах нягтлан бодогч Ө.Мандухай нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

P. Duj

B. M.

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.МӨНХЦАЦРАЛ

9006109
9019120396

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherag\Alban_Shaardlaga\2022\0225_Auditin_2_Gazar-51.Docx

001080149



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 89/А0160043

Улаанбаатар хот

АХГ-2022/347/НА-СТА-ТШЗ.

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бүгд Найрамдах Солонгос Улсын санхүүжилтээр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн гүйцэтгэгчид олгосон санхүүжилтийн хэрэгжилт, бүртгэлд тавих хяналт сул байгаагаас төслийн хөрөнгөөс бэлтгэсэн 7,200,000.00 төгрөгийн зөөврийн компьютерыг зориулалт бусаар ашигласан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, дотоод хяналтыг сайжруулах, дээрх зөрчлийг арилган албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Ахлах нягтлан бодогч Ө.Мандухай нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.МӨНХЦАЦРАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

9006109
9019 \10.10.10\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0225_Auditin_2_Gazar-52.Docx

001080152